

хувилбараар шийдэхэд хөрс суурь бэлтгэж өгнө гэж үзэж байна.

Нөгөө талаас Японы эрчим хүчний "крантыг хаах" эрхийг Оросын тал авчихна гэсэн бүр Брежневийн үеэс гаралтай улс төрийн болгоомжлол хардлага өнөө ч Японд хүчтэй хэвээр байна. Өөрөөр хэлбэл, Оросоос их хэмжээний байгалийн хий авч ашиглах нь тэдэнд Японы эрчим хүчний аюулгүй байдалд нөлөөлөх боломж олгоно гэсэн сөрөг саналыг Японы зарим улс төрийн зүтгэлтнүүд тавьж байгаа юм. Түүнчлэн Сибирь болон Монголын зэлүүд газар нутгийг дайруулан хийн хоолой татах ажилд Япончууд тийм их хөрөнгө хаях нь утгагүй хэрэг гэж үздэг Японы засгийн газрын гишүүд ч бий.

**Өмнөд Солонгос XXI зууны  
Япон мөн үү**

*Дэд доктор Д.УЛАМБАЯР (ОУХДС)*

**1. Хөгжлийн загвар**

Хүн төрөлхтөн өнөөгийн ирмүүн хөгжлийн өндөрлөгт тулж ирэхдээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн үр ашиг бүхий хэд хэдэн загварыг бүтээн бий болгожээ.

НЭГДЭХ нь Өрнө дахины хөгжингүй орнуудын загвар бөгөөд энэ нь 1640-оны Английн Хөрөнгөтний аугаа их хувьсгалаар гараагаа эхэлж, 1776 оны Америкийн Тусгаар тогтнолын Тунхаглал, 1787 оны Америкийн Анхдугаар Үндсэн Хууль, 1789 оны Францын Хөрөнгөтний Их Хувьсгал түүний үр дүнд батлагдсан Хүн ба Иргэний Эрхийн Түгээмэл Тунхаглал, 1865 онд ялсан Америкийн Хөрөнгөтний Хувьсгалаар бэлтгэгдэж өнөөг хүрч ирсэн буюу УЛС ТӨРИЙН АРДЧИЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ДЭЭР ЭДИЙН ЗАСГИЙН АРДЧИЛАЛЫГ хөгжүүлж ирсэн загвар юм. Энэ нь бараг 20 гаруй жилийн түүхэн хөгжлөөр бий болжээ. ХОЁР ДАХЬ ГЭЖ ХЭЛЖ болох Скандинавийн хойгийн орнуудын хөгжлийн загвар бол НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ төвдөө тавьж УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН АРДЧИЛАЛЫГ хөгжүүлж ирсэн загвар билээ. Энэхүү загвар энэ зууны эхээр бэлтгэгдэж Дэлхийн II дайны дараа эрч хүчээ авч өнөөг хүрч ирсэн байна. Хөгжлийн ГУРАВ ДАХЬ загвар бол Азийн шинээр аж үйлдвэржсэн орнуудын туршлага билээ. Сүүлийн гурван 10 жилд буй болсон энэ загвар нь ЭДИЙН ЗАСГИЙН АРДЧИЛАЛЫГ хөгжүүлэх үндсэн дээр УЛС ТӨРИЙН АРДЧИЛАЛЫГ хөгжүүлж иржээ. Азийн шинээр аж үйлдвэржсэн гэх Өмнөд Солонгос, Сингапур, Тайван, Гонконг зэрэг орнууд зах зээлийн эдийн засгийг төрийн хүчтэй зохицуулалтай хослуулжээ. Үнэхээр ч сайхь

орнуудад феодалын харилцаа гүн суурьтай байсан нь барууны орнуудын ардчилалыг тэр чигээр нь хуулан авах боломж, нөхцөл бүрдээгүй байсан юм. 50-иад оны сүүлээр Өмнөд Солонгос, Тайвань, Сингапур сонгодог либерализмын загварыг туршсан боловч тэр нь хөгжлийг түргэтгэх гол хүчин зүйл биш гэдэг нь удалгүй харагдсан билээ. Хэдийгээр цэргийн болон нэр хүндийн дэглэм эдийн засагт хүчтэй оролцож байсан боловч зах зээлийн бодит хуулиудыг үр ашигтай хэрэглэж чадвал эдийн засгийн зохих төвшинд хүрч болохыг энэ туршлага харуулсан юм. Хятад, Вьетнам ч коммунист намын удирдлагын дор зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж энэ нь ч үр дүнгээ өгсөөр байна. Нээлттэй эдийн засаг, экспортын чиглэлтэй бүтэц, гадаадын шууд хөрөнгө оруулалт, олон улсын санхүүгийн зээл, тусламж чухал хүчин зүйл болсон гэдэг нь өнөөдөр ойлгомжтой билээ.

Нийгмийн хөгжлөөр доогуур төвшинтэй улс орнууд хөгжлөө хурдасгах бололцооны тухай үзэл, онол өнгөрсөн зууны сүүлээр боловсорсон билээ. Германы гүн ухаанч К.Маркс "Энэтхэг дэх Их Британы Эзэмшлийн Ирээдүйн Үр дүн" бүтээлдээ хоцрогдсон бага буурай орнууд нийгмийн хөгжлөө хурдасгаж тухайн үеийн өндөр хөгжилтэй Англи мэт орны төвшинд ойртоход сайхь улс шиг заавал бусдыг колончлон ажиллах хүчнийг нь мөлжиж, эд баялагийг нь дээрэмдэн өөрийн аж үйлдвэрээ хөгжүүлж, капиталын хуримтлалыг буй болгосон тэр замыг сонгох албагүй бөгөөд үүнийгээ К.Маркс зүйрлэхдээ мөнхийн усыг хүртэхдээ заавал үхсэн хүний гавлын ясаар хийсэн аягаар уух албагүй, харин хөрөнгөтнүүдийн үйлдвэрлэл эрхэлж байгаа арга, түүнийг зохион байгуулж байгаа тэр хэлбэрийг л ашиглах явдал гэж бичжээ. Харамсалтай нь хожим үүнийг мушгин гуйвуулж "капиталист биш хөгжлийн замын" онолын үндэс болгосон билээ.

## **II. Алс дорно дахины хоёр дахь Япон**

1989 онд Солонгос гаралтай Японы судлаач Т.В.Кангийн бичсэн "Өмнөд Солонгос нь Ирэх Зууны Япон мөн үү" нэртэй бүтээл Нью-Йорк хотноо хэвлэгдэн гарсан нь нилээд дуулиан тарьсан билээ. Уг нь зүүн ази, номхон далайн хэсэг орон үйлдвэрлэлийн бүтэцийг шинжлэх ухаан, технологийн үндсэн дээр шинэчилж, экспортын чиглэлтэй бодлого явуулснаар (үндсэндээ хөгжлийн Японы загвараар) эдийн засгийн өсөлтийг эрс хурдасгаж байгааг бүр 1975 онд өрнөдийн стратегийн судалгааны нэртэй төвүүдийн дүн шинжилгээг үндэслэн Америкийн TIME сэтгүүл анхааруулан бичиж байжээ. Өнөөгийн Өмнөд Солонгос нь эдийн засаг, шинжлэх ухаан техникийн урьд үзэгдээгүй ахицыг ирэх зуунд гаргах материал болон оюун санааны үлэмж чадавхитай орон гэж өрнөдын судлаачид тэмдэглэж байна. Үнэндээ өрнөдийн судлаачдын зарим бүтээлд Өмнөд Солонгосыг "Алс Дорнодын Хоёр дахь Япон" гэж томъёолсон нь бий. 1996 оны 4 сард Солонгосын Хөгжлийн Хүрээлэнгээс эрхлэн Засгийн Газар, эрдэмтэд, судалгааны томоохон хүрээлэн, үйлдвэр худалдааны бүлгийхэн оролцсон

Think Tank Солонгосын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал ба хөтөлбөрийг эцэслэн боловсруулж гаргажээ. Энэхүү стратегийн зорилт ёсоор бол Өмнөд Солонгос нь 21 зууны 20 он гэхэд эдийн засгийн хүчин чадавхиар 7-гийн бүлэгт баттай багтаж дотоодын нийт бүтээгдэхүүн 4 триллион доллар, худалдааны нийт эргэлт 2,44 трилл долларт хүрэх учиртай ажээ. Энэ нь ДНБ-нээр дэлхийд долоо дахь, худалдаагаар зургаа дахь том гүрэн болно гэсэн үг. Урьдчилсан дүгнэлтээр инфляцийг 3 хувьд байлгаж 2020 он гэхэд ДНБ-ний нэг хүнд оногдох хувийг 80,000 долларт (1995 оны үнээр) хүргэнэ гэжээ. Шинжлэх ухаан, технологийн чадавхиар ч 7-гийн бүлэгт нэгэнтэй багтаж аж үйлдвэрийн салбар дахь нарийн технологийн эзлэх хувь 13 хувь байсан бол 2020 онд 45 хувь болж өсөх ажээ. Судалгаанаас гаргасан илтгэлд ДНБ-нээр дэлхийд АНУ 26,9 триллионоор нэгд, Хятад 26,9 триллионоор хоёрт, Япон 11,2 триллионоор гуравт, Герман 7,1 триллионоор дөрөвт, Франц 4,47 триллионоор тавд, Итали 4,4 триллионоор зургаад, Өмнөд Солонгос 4,0 триллионоор долоо дахь байранд орох юм. Дэлхийн Банкнаас гаргасан илтгэлд 2020 онд Хятад, АНУ, Япон, Энэтхэг, Индонез, Германы дараа орж эдийн засгийн хүчин чадлаар дэлхийн долоо дахь гүрэн болно гэж урьдчилан дүгнэжээ. Энэ нь Франц, Англи, Итали, Канадыг ардаа орхино гэсэн үг юм. Швейцарын Холбооны Банкнаас гаргасан илтгэлд ч 21 зууны эхний 2 арван жилд Солонгос нь дэлхийн эдийн засагт гол хүчирхэг өрсөлдөгч арван орны нэг гэж үзсэн байна. Нэртэй төвүүдийн ойрмогхон гаргасан дүгнэлтүүдээс үзэхэд 2020 он гэхэд Солонгос нь эдийн засгийн чадавхиар 7 дахь гүрэн болно гэдгийг үнэмшихэд хүргэж байна.

### Хүснэгт 1

#### 21-р зууны дэлхийн эдийн засаг дахь солонгос

(нэгж: тэрбум ам доллар)

д	1995		2000		2010		2020	
д	Улс	ДНБ	Улс	ДНБ	Улс	ДНБ	Улс	ДНБ
1	АНУ	7078	АНУ	8879	АНУ	15604	АНУ	26908
2	Япон	5000	Япон	5300	Япон	7844	Хятад	12278
3	Герман	2414	Герман	2692	Хятад	4690	Япон	11281
4	Франц	1545	Франц	1688	Герман	4343	Герман	7142
5	Англи	1109	Хятад	1432	Франц	2749	Франц	4478
6	Итали	1087	Итали	1413	Итали	2531	Итали	4405
7	Бразил	741	Англи	1295	Англи	2171	Ө. Солонгос	4081
8	Хятад	649	Бразил	909	Ө. Солонгос	2051	Англи	3638
9	Канад	570	Ө.Солонгос	851	Бразил	1568	Бразил	2506
10	Испани	557	Канад	720	Канад	1129	Испани	1968
11	Ө. Солонгос	456	Испани	631	Испани	1120	Канад	1688

Эх сурвалж: Солонгосын хөгжлийн хүрээлэн, 1998 оны 4 сар

1997 оны 4 сард Олон Улсын Валютын Сангаас гаргасан "Дэлхийн Эдийн Засгийн Байдал Төлөв" илтгэлд улс орнуудын хөгжлийн ангилалыг шинэчилж" тэргүүлэх эдийн засаг"-тай орнуудын тоонд азийн шинээр аж үйлдвэржсэн 5 орон Сингапур, Өмнөд Солонгос, Тайвань, Гонгконг болон Изриалийг оруулсан байна. Аж үйлдвэржсэн хөгжингүй 7 орноос гадна "тэргүүлэх эдийн засаг"-тай 16 орон нь Эдийн Засгийн Хамтын ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын (OECD) гишүүн Нидерланд, Бельги Австри, Швейцарь, Ирланд, Исланд, Грек, Финлянд, Норвеги, Дани, Испани, Португал, Люксембург, Австрали, Шинэ Зеланд, Швед билээ.

1960-1970-аад онд Японы Хөгжлийн стратеги нь "хөөж гүйцэх", 1980-аад он гэхэд "гүйцэж түрүүлэх" философи байсан бөгөөд энэ нь ч ёсоор болсон билээ.

Энэ стратеги ч азийн шинээр аж үйлдвэржсэн орнуудын тухайлбал Солонгосын хөгжлийн баримтлал болж байна. Өнөөдөр хөгжингүй болон тэргүүлэх эдийн засагтай орнуудын эдийн засгийн дундаж өсөлт дөнгөж 1,5 аас 2,5 хувь байхад Азийн "бар" орнуудын хувьд 7-8 хувь байгаа нь "хөөж гүйцэх" стратеги ирэх зууны эхний 20 жилд биелэх найдвар төрүүлж байна. Солонгосын Худалдаа, Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Агентлаг (KOTRA), Германы Эдийн Засгийн өдөр тутамын сонин "Ханделсватт"-ын гаргасан илтгэлд ирэх зуунд хоёр солонгос нэгдсэн тохиолдолд Зүүн Хойд Азийн хүчний тэнцвэрт ноцтой өөрчлөлт орно гэж үзэж байна.

Өнөөгийн байдлаар Өмнөд Солонгос болд, ган хайлуулах үйлдвэрлэл, автомат удирдлагатай зарим суурь машин, нэхмэлийн үйлдвэрлэлээр Японы урьд нэгэнтээ гарч авто машины үйлдвэрлэлээр дэлхийд тавд, хөлөг онгоцны үйлдвэрлэлээр хоёрт орох болов. Мэдээж Солонгост шийдвэрлэх олон чухал асуудал бий. Юуны өмнө урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахад Солонгосын хойгт аюулгүйн бат найдвартай тогтолцоог буй болгож хоёр солонгосын хооронд дээд төвшинд яриа хэлэлцээр хийх явдал юм.

## **II. Хямралын эхлэл ба солонгосын жил орсон нь**

Монголчууд Морин жилийг ихэд бэлэгшээхийн дээр өөрсдийгөө Бэрт Чоноос гаралтай гэж үздэг билээ. Харин Солонгосчууд өөрсдийгөө Бараас гаралтай гэж үзнэ. Тиймээс ч Сөүлийн олимпын бэлэг тэмдэгийг бараар дүрсэлсэн нь учиртай. 4333 жилийн өмнө бурхан тэнгэр Бар, Баавгай хоёрыг газар дэлхийд илгээжээ. Ертөнцийн эзэн сайхь хоёрыг явахын өмнө хэлсэн нэгэн захиас нь дэлхийд газардаад 100 хоног хар ус, хагд өвс чамсахгүй байхыг учирлан захижээ. Гэвч баавгай захиасыг эс тэвчиж харин Бар тэнгэрийн эзний зарлигыг ёсоор болгосонд тэрбээр үзэсгэлэнт хунтайж болон хувирч Пэгтусан уулын урьд хормойд үзэсгэлэнт гоо гүнжтэй учирч тэд айл болон амьдарч Солонгос үндэстэн үүссэн хэмээх нэгэн домог байх ажээ.

1998 оны 2-р сарын 25-нд сөрөг хүчнээс анх удаа ерөнхийлөгчид сонгогдсон Ким Дэ Жунийн тангараг өргөх ёслолд зориулсан багт наадмын

үеэр хүч тамир нь сульдсан асар том бар хэвтрээсээ өндийж архиран босч байгаа үзүүлбэр онцгой сэтгэгдэл төрүүлж билээ. Сүүлийн 30 гаруй жилийн түүхэнд зүүн азийн хөгжлийн загварыг буй болгож "Азийн бар" болсон энэ орон өнгөрсөн оны сүүлчээс эдийн засгийн гүн хямралд орсон ч 1998-оны Бар жилд дахин шинээр мэндэлж байгааг илтгэсэн хэрэг байв. Үнэхээр ч Солонгосчуудын хувьд жил нь орж байгаа билээ.

Өмнөд Солонгосын санхүү эдийн засгийн хямралын шалтгааныг тодорлуулахад бүс нутгийн валют, санхүүгийн хямралын эх сурвалжаас эхлэн тайлбарлахаас өөр аргагүй билээ. Дэлхийн эдийн засагт 1997 оны 7 сард тохиолдсон үйл явдлын нэг нь Зүүн Өмнөд Азийн орнуудын санхүү, эдийн засгийн хямрал байв. Энэхүү хямрал 1997 оны 7 сард Тайландад эхэлж улмаар Зүүн Өмнөд Азийн хэд хэдэн оронд нөлөөлсөн байна. (Инодонез, Малайз, Филиппин, Сингапур, Өмнөд Солонгос, Тайландын үндэсний валют болох баатын ханш 7-р сарын 4-нд 80 гаруй хувиар огцом унаж нэг ам доллар 25 орчим баат байснаа 45-д хүрсэн нь бүс нутгийн хямралын эхлэл болсоон. Мөнгөний ханш унасны улмаас тус улсын хувийн хэвшийн зээлийн үндсэн өр болон хүүгийн төлбөр ихээхэн өсч эдийн засагт дарамт учруулжээ. Энэ нь үнэт цаасны зах зээл дээр үнийн хөөрөгдөл гаргахад нөлөөлж ханш унаснаас гадаадын хөрөнгө оруулагчид хөрөнгөө татаж эхлэв. Улмаар уг үйл явц үнэт цаасны тэртээ тэргүй унаж байсан ханшийг улам унагасан төдийгүй тус улсын үндэсний валют баатын ханшийг илүү хүчтэй унагахад нөлөөлж, цаашид банк санхүүгийн тогтолцоо ноцтой хүнд байдалд орж эхэлжээ. Ийнхүү Тайланд дахь хямрал бүс нутгийн үнэт цаасны арилжаа, ханшид нөлөөлж 1997 оны 9-р сараас Малайзын рингит, Индонезийн рупий, Филашиний песо, Сингапурын Доллар, Өмнөд Солонгосын Воны ханш огцом унасан нь хямрал бүс нутгийн шинж чанартай болохыг харуулав. Гол шалтгаан нь эдийн засгийн хэт өсөлт буюу халалт макро эдийн засаг болон валютын арилжааны бодлогын алдаа, санхүүгийн секторын зохион байгуулалт, бүтэц сул, эдийн засагт төрийн оролцоо их байсан мөн гадаад нөлөө, хээл хахуул зэргийг дурдахад хангалттай.

Өмнөд Солонгосын хувьд импортоор түүхий эд авдаг үйлдвэрүүдэд ханш уналт хүндхэн цохилт болж энэ нь ажилгүйчүүдийн тоог өсгөхөд нэмэр болов. Гадаад хөрөнгө оруулалт, дунд болон богино хугацааны зээл түүнчлэн арилжааны зээлийн дийлэнхи хувь том үйлдвэр, худалдааны бүлгийнхний гарт очдог нь жижиг, дунд үйлдвэрүүдийг үйлдвэрлэл, үйлчилгээгээ өргөтгөх, техник, технологийн шинэчлэл хийхэд улмаар ажлын нэмэгдэл байр бий болгох боломжийг хумьсан юм. Томоохон бизнес группууд асар их хэмжээний зээлийг үр ашиг багатай нүсэр салбаруудад зарцуулсан нь өнгөц харахад эдийн засгийн өндөр өсөлтийг харуулсан боловч энэ нь барааны хэт илүүдлийг бий болгож экспорт буурахад хүргэж төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал өсөхөд нөлөөлжээ. Солонгосын эдийн засгийн өндөр өсөлтөд капиталын гадаад миграци буюу гадаадын хөрөнгийн урсгал ихээхэн

үүрэг гүйцэтгэсэн юм. Энэхүү хөрөнгийн өчүүхэн хэсэг нь шууд хөрөнгө оруулалт буюу урт хугацааны хөрөнгө оруулалт эзэлж бусад нь богино хугацаат хөрөнгө оруулалт байжээ. Богино хугацаат хөрөнгө оруулалт ДНБ ний 7 орчим хувийг эзэлж байсан бол шууд хөрөнгө оруулалт дөнгөж 1 хувь байжээ. Иймээс богино хугацаат хөрөнгө оруулалтын өрийг дарахад байнга хүндрэл учирч улмаар санхүүгийн секторт итгэх итгэл хөрөнгө оруулагчдад буурсан байна. Тиймээс Ханбу, Жинро, Самми, Киа болон бусад долоон томоохон бизнесийн групп, 10 арилжааны банк, брокерын пүүсүүд дампуурлын ирмэгт ирж зарим нь бүр дампуурсан байна. 1998 оны 3-р сарын 1-ны байдлаар 3000 шахам ЖДУ дампуурсан байна. Самсунг, Эль Жи, Санкёнг, Хёндэ, Дэу группээс бусад томоохон компаниудын гүйцэтгэл зээлийн хүүгээс доогуур буюу 12 хувиас доош хэмжээнд оржээ. Хөрөнгө оруулалтын ашгийн үзүүлэлт аливаа пүүс компанийн ашигт ажиллагааг тодорхойлдог. Менежмент хамгийн гол үзүүлэлт юм. Хөрөнгө оруулалтын ангийн үзүүлэлт зээлийн хүүгээс доогуур байвал бизнес явуулснаас бонд гаргах нь илүү үр дүнтэй гэж олон улсын эдийн засагчид үздэг ажээ.

Төсвийн тэнцлийн ашиг, алдагдлын харьцааг дутуу үнэлснээс макро эдийн засгийн бодлого алдагдахад хүрсэн, эдийн засгийн өндөр өсөлтөдөө хэт тайвшран төсөв, мөнгөний хатуу бодлого явуулаагүйгээс хямрал гарах нэг нөхцөл болжээ. Өмнөд Солонгосийн санхүүгийн сектор засаг төр болон цөөн тооны том компанийн оролцоонд суурилсан, үйл ажиллагаа нь нийтэд ил тод биш хээл хахуульд гүн автагдсан нь бас нэг учир шалтгаан юм.

Гадаад нөлөөллийн хувьд 1997 оны эхээр АНУ Холбооны нөөц, дотоод зах зээлээ өргөжүүлэхийн тулд богино хугацаат зээлийн хүүг өргөсөн. Сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалтаас орох ашиг аж үйлдвэржсэн болон хөгжингүй орнуудад өссөн нь капиталын урсгал хөгжиж буй зах зээлээс аж үйлдвэржсэн орнуудын зах зээлд шилжих хандлагатай болсон. Өмнөд Солонгос нь импортын хувьд Японоос багагүй хамааралтай байдаг нь Японы үндэсний валют иений ханш 1997 оны дундаас мэдэгдэхүйц доошилсон нь барааны өрсөлдөх чадварт нөлөөлж цэвэр экспортын өсөлтөнд эсрэг нөлөөлсөн төдийгүй төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдлыг нэмэгдүүлсэн байна.

Хэдийгээр Өмнөд Солонгос санхүү, эдийн засгийн гүн хямралд орсон боловч Зүүн Өмнөд Азийн бусад орныг бодвол хямралаас хамгийн бага хугацаанд үр дүнтэй гарч байгаа орон гэж олон улсын санхүүгийн мэргэжилтнүүд нэгэнтээ тэмдэглэлээ. Солонгосын Засгийн Газар ОУВС-ын авралын 57 тэрбум долларын зээлийг банк, санхүүгийн тогтолцоог шинэчлэх, ЖДУ-уудийг дэмжих, макро эдийн засгийг тогтворжуулах, ханш уналтыг барих зэрэг олон чухал арга хэмжээнд зарцуулж эхэллээ. Шинэ Засгийн Газар улс орон даяар алт цуглуулах хөдөлгөөн өрнүүлж 240 тн алтыг нэгэнт Сингапур дахь Олон Улсын банканд борлуулсан байна. 1998 оны 2-р сарын сүүлчээр Өмнөд Солонгосын гадаад өр 150,3 тэрбум доллар байсан

нь өмнөх сарынхтай харьцуулахад 900 саяар буурав. 2-р сард тус улсын удаан хугацааны гадаад өрийн хэмжээ ОУВС-гийн тусламжийн зээлийг оролцуулаад 1,7 тэрбумаар өссөн байхад хувийн хэвшлийн богино хугацааны өр 2,6 тэрбум доллараар буурсан байна.

Хямрал эхлэхийн өмнө Өмнөд Солонгосын гадаад валютын нөөц 9 тэрбум доллар байсан бол нөөцийн хэмжээ он гарсаар 24 тэрбумаар өсчээ. Статистикийн бүртгэлд ордоггүй, татварт хамрагддаггүй, урсгалаар их хэмжээний гадаад валют гадагшилж байгаа шалтгаан нь хууль бусаар тус оронд ажиллаж байгаа гадаадынхан гэж үзэж тэднийг нутагт нь буцаах бодлого барих болов. Мөн эдийн засагт төрөөс хэт оролцож байгааг зогсоох бодлого баримтлах Үндсэн Хуулиндаа өөрчлөлт оруулж засаглалын тогтлолцоог өөрчилж ерөнхийлөгчийн засаглалаас кабинетийн тогтолцоонд шилжих бэлтгэл ажил нэгэнт эхэлж 2000 оноос хэрэгжүүлэх болов.

Канадын Ванкувэрт хотноо болсон АПЕК-ийн дээд хэмжээний уулзалт дээр АНУ-ын ерөнхийлөгч Билл Клинтон хэлэхдээ эдийн засгийн хүчин чадлаар дэлхийд 11-т ордог дайны дараах "эдийн засгийн зэрэглээнд" "таван барын" нэг болж байсан Өмнөд Солонгос хямралаас богино хугацаанд гарч чадах орон мөн гэж онцлон тэмдэглэсэн юм. "Бид Өмнөд Солонгосын засгийн газрын зарласан шинэтгэлийн хөтөлбөрийг бүрэн дүүрэн сайшаан дэмжиж байна" гэж Дэлхийн банкны ерөнхийлөгч Жеймс Вольфенсон 10 тэрбум долларын зээл олгохын өмнө мэдэгдсэн билээ. Үнэхэр Өмнөд Солонгос 21 зуунд тогтвортой хөгжлийнхөө замд орох чадавхитай орон юм.

#### **IV. Өмнөд Солонгос Монгол Улсын стратегийн түнш мөн**

Монгол Солонгос хоёр түүх, соёлын өнө эртний уламжлалтай билээ. Бүр 995 онд Кидан гүрэн Гуулин улстай соёлын харилцаа тогтоож 10 хүүхэд Монгол нутагт түүх, хэл сурахаар ирж байжээ. Хоёр тал 1995 онд 1000 жилийн ойг нь тэмдэглэсэн билээ. Хоёр орон дэлгэр харилцаатай байсан 13 зуунд Гуулин улсын гадаад харилцааны албанд ажиллах түшмэдээс монгол хэлний шалгалт авдаг байсан тухай Гуулин улсын дипломатын түүхэнд тэмдэглэсэн нь бий. Монголчууд Корё улсыг "Солонгос" хэмээн нэрлэдэг нь зарим судлаачид монгол хэлний "солонго" гэдэг үгнээс гаралтай учир нь солонгос үндэсний хувцасны ханцуйг өнөө хэр солонгын өнгөөр эмждэг заншилтай холбон тайлбарласан байдаг. Мөн 1918 онд Солонгосын тусгаар тогтнолын хөдөлгөөний нэртэй зүтгэлтэн доктор Ким Кю-Сик Америкийн томоохон компани "Андерсон энд Мейнер" пүүсийн Нийслэл Хүрээн дэх салбарт ажиллаж байгаад дараа жил нь Францаар дамжин Америкт одсон тухай баримт байдаг. 1919 оны үед Монгол-Хятад, Монгол-Оросын харилцаанд солонгос хүн зуучлагчаар оролцож байсан баримт ч бий. Мөн 1922 онд МАХН-ын дарга С.Данзан солонгосын иргэн Ё Чи-Хёнг гэдэг хүнд Хүрээнд

байхад нь паспорт олгоход тусалж тэд хамтдаа Москва явж дарлагдсан хөдөлмөрчдийн Их хуралд оролцжээ. 1939 оны Халх голын байлдаанд Японы Квантуны армид хүчээр дайчлагдсан солонгосчууд Монгол-Зөвлөлтийн цэргүүдэд олзлогдож байсан баримт гээд гүнзгийрүүлж судалбал сонирхолтой цөөнгүй баримт, материалууд бий юм. Нилээд сүүлийнх гэвэл 1979 оны 8 сард Монгол-БНСУ-ын хооронд спортын салбарт солилцооны үүд нээгдэж сонгомол барилдааны дэлхийн VI удаагийн аварга шалгаруулах тэмцээнд Өмнөд Солонгосын 14 тамирчин Улаанбаатарт иржээ. 1980 оны 10 сард Улаанбаатарт болсон Чөлөөт бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Өмнөд Солонгосын бүрэн бүрэлдэхүүнтэй тамирчид, сурвалжлах хэсгийнхэнтэйгээ оролцсон байна. 1983 онд Сөүлд болсон Олон Улсын Парламентын бага хуралд Монголоос гурван төлөөлөгч анх удаа оролцжээ. 1987 оны 9 сард Улаанбаатарт болсон Номхон далайн орнуудын парламентын зөвлөлгөөнд Солонгосын гурван төлөөлөгч оролцсон байна. 1990 оны 3 сард Монгол БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосноос хойш хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж байна. Өмнөд Солонгосын Төв Банкнаас гаргасан 1997 оны мэдээнд худалдааны нийт эргэлт 49,1 сая ам долларт хүрч үүнээс манай экспорт 32,4 сая, импорт 16,1 сая ам доллар түүнчлэн 5,4 сая ам долларын шууд хөрөнгө оруулалт мэдээлэл, холбоо, оёдол, нэхмэл, эмнэлэг, ажил, үйлчилгээний салбарт хийгджээ. БНСУ-ны Засгийн Газрын хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр нэг удаагийн тариурын үйлдвэр ашиглалтанд орсон. Өмнөговийн Даланзадгадын дулааны цахилгаан станцыг санхүүжүүлэх БНСУ-ын Засгийн Газраас 1991 онд олгосон хөнгөлттэй зээлийн үлдэгдэл 8,8 сая ам долларын асуудал 1997 оны 8 сард шийдэгдэв. Тэдний томоохон нэртэй компаниуд манай уул, уурхай, газрын тос, дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулах сонирхолтой байна. Манайх БНСУ-д хүн сургах чиглэлээр өргөн боломж бий. Зүүн Хойд Азийн Эдийн Засгийн хамтын ажиллагааны хүрээнд тухайлбал Түмэн голын төслийн хүрээнд хамтран ажиллах өргөн боломжтой. Мөн Монголын нутгаар дамжуулан тавих хийн хоолой, Дорнодын чөлөөт худалдааны бус байгуулах, олон улсын төмөр болон авто замын сүлжээнд хамтран оролцох, газрын тосны салбарт хамтын ажиллагааны нөөц бий. 1993 оны 10 сард болсон БНСУ-ын парламентын нэгэн хуралдаанаар Монгол улсын тухай асуудал яригдаж бидний монголд явуулах бүх талын үйл ажиллагаа Японоос илт хоцорч байна гэж үзсэн юм. Ер нь БНСУ бол Зүүн Хойд Азийн гео бүсэд Японы дараа орох манай стратегийн түнш мөн гэж үзэж болно.

#### **V. Төрсгөл**

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд Ази-Номхон далайн бус нутагт онцлон Азийн шинээр аж үйлдвэржсэн орнуудтай тухайлан Өмнөд Солонгос улстай бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар онцгойлон заасан билээ. Тэгээд ч Олон улсын эдийн засгийн харилцааны төв Ази

---

Номхон далайн бүс нутагт шилжиж байгаа нь илт болжээ. Ази Номхон далайн сав нутаг байгалийн асар их баялаг, өргөн уудам тал, элс манхан, хараа цуцам мөнх цаст оргил, байгалийн тансаг дүр төрх, арслан барсаас аваад аварга том халим загас хүртэл сэтгэл булаам ан амьтан, хүн зоны гайхам өвөрмөц ёс заншил, түүх соёлын давтагдашгүй өв дурсгал, шинжлэх ухаан технологийн хачин сонин бүтээл зэрэг энэхүү өнгөлөг өөдрөг бүхэн "Дорно дахин" хэмээх нэрийн дор алдаршиж гадна, дотны айлчин гийчний сонирхлыг эртнээс эрхгүй татсаар иржээ. Түүнчлэн түүхий эдийн эх булаг, капитал оруулах хүрээ, борлуулалтын зах зээл, шинжлэх ухаан технологийн хамгийн тэргүүлэх салбарт өрсөлдөөн өрнөж байгааг ч бид харж байна. К.Маркс өнгөрсөн зууны дундуур өөрийн бичсэн "Олон улсын тойм" бэсрэг бүтээлдээ "Олон улсын харилцааны аугаа их замын үүргийг эртний дэлхийн дахинд Газрын Дундад Тэнгис гүйцэтгэж байв. Энэ үүргийг одоо Атлантын далай үүрч явна. Чухамхүү ирээдүйд энэхүү үүрэг нь Номхон Далайд ноогдох болно" гэж нэгэнтээ хэлсэн нь нотлогдож байна.